



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

「Шүүгчийн сонгон шалгаруулалтын шалгалтын
арга, хэлбэр, үнэлэх аргачлал батлах тухай

Шүүхийн захиргааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 15 дугаар зүйлийн 15.2, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 13 дугаар зарлигаар баталсан “Шүүгчийг сонгон шалгаруулах” журмын 1.6-д заасныг тус тус үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ТОГТООХ нь:

Шүүгчийн сонгон шалгаруулалтын шалгалтын арга, хэлбэр, үнэлэх аргачлалыг хавсралтаар баталсугай.

ДАРГА  Н.ЛҮНДЭНДОРЖ



000031

ШҮҮГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ШАЛГАЛТЫН АРГА, ХЭЛБЭР, ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

УХА0052 1701517

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 13 дугаар зарлигаар баталсан “Шүүгчийг сонгон шалгаруулах” журмын 1.6-д заасны дагуу Шүүхийн мэргэшлийн хороо /цаашид “Мэргэшлийн хороо” гэх/ бүх шатны шүүхийн шүүгч, анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн сонгон шалгаруулалтын шалгалтын арга, хэлбэрийг тогтоох, үнэлэхэд энэ аргачлалыг баримтална.

1.2. Энэ аргачлал Монгол Улсын Үндсэн хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 13 дугаар зарлигаар баталсан “Шүүгчийг сонгон шалгаруулах” журамд нийцсэн байна.

1.3. Мэргэшлийн хорооны гишүүн сонгон шалгаруулалтын өмнө Мэргэшлийн хорооны гишүүний ёс зүйн дүрэмтэй дахин танилцаж, шалгалтын явцад дүрмийг чанд баримтална. Мэргэшлийн хорооны гишүүн үнэлгээг хараат бусаар, бие дааж гаргана.

1.4. Энэ аргачлалд заасны дагуу тухайн шалгалтыг ямар арга, хэлбэр, шаардлагын дагуу явуулах тухай нэр дэвшигчдэд шалгалт тус бүрийн өмнө дэлгэцээр харуулж, мэдээлнэ.

Хоёр. Даалгавар боловсруулах, үнэлэх

2.1. Мэргэшлийн хорооны дарга шалгалтын даалгавар боловсруулах мэргэжилтнийг сонгож, нууцлалын гэрээ байгуулна. Шалгалтын даалгавар хуульд заасан болзол, шаардлагыг шалгаж чадахуйц төвшинд байна. Даалгаварын нууцлалыг Мэргэшлийн хорооны дарга хариуцна.

2.2. Эрх зүйн тохиолдол шийдвэрлэх шалгалтыг үнэлэхдээ тухайн салбар эрх зүйн тохиолдол шийдвэрлэх нийтлэг аргачлалыг баримтална.

2.3. Сорилын асуулт нь сонголтот 4-өөс доошгүй хариулттай байх бөгөөд үүнээс 1 хариулт зөв байна.

2.4. Нэр дэвшигчийн монгол хэлний болон мэдээллийн технологийн хэрэглээний чадвар, ёс зүй, зан төлвийг тухайн чиглэлийн мэргэжилтний дүгнэлтийг харгалзан үнэлж, дүгнэж болно.

2.5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 166 дугаар зарлигаар батлагдсан Мэргэшлийн хорооны дүрмийн 5.3-д заасны дагуу нийт гишүүдийн

дийлэнх олонхын үнэлгээний дунджаар нэр дэвшигчийн шалгалт тус бүрийн үнэлгээг гаргана.

2.6. Анхан болон хяналтын шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн нэгдсэн үнэлгээг суурь болон тусгай шалгалтын онооны дунджаар гаргана.

Гурав. Анхан шатны шүүхийн шүүгчийн шалгалт



3.1. Суурь шалгалт.

3.1.1. Ёс зүй, зан төлөв 70 хүртэл оноо

3.1.1.1. Сорилын шалгалт 30 хүртэл оноо.

3.1.1.1.а. хуульчийн болон шүүгчийн ёс зүйн мэдлэгийг нэг асуулт 0.5 оноо бүхий сорилоор шалгана. Сорилын хариуг тусгай төхөөрөмжөөр шалгана. Сорилыг шалгахад нэр дэвшигчийг байлцуулна. Нийт нэр дэвшигчийн сорилын шалгалтын хариуг төхөөрөмжид уншуулж дуусмагц сорилын зөв хариултыг нэр дэвшигчдэд дэлгэцээр танилцуулна.

3.1.1.2. Ярилцлага 30 хүртэл оноо.

3.1.1.2.а. ярилцлагын шалгалтаар нэр дэвшигчийн хувь хүний ёс зүй, шүүгчээр ажиллах зан төлөвийг (judicial temperament) таньж мэдэх, тодорхойлох, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх болон ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чадвар, хандлагыг үнэлнэ. Нэр дэвшигчтэй тодорхой жишээ, тохиолдолд тулгуурлан урьдчилан бэлтгэсэн асуултын хүрээнд ярилцана.

3.1.1.2.б. нэр дэвшигч бүртэй хийх ярилцлагын хугацаа 10 минут байна. Мэргэшлийн хорооны ажлын алба ярилцлагын цагийг нэр дэвшигчид харуулж, цагт хяналт тавина.

3.1.1.2.в. ярилцлагыг бусад нэр дэвшигч хөндлөнгөөс ажиглаж болно.

3.1.1.2.г. ярилцлагын явцад мэргэжлийн сэтгэл зүйчийг байлцуулж, дүгнэлт гаргуулж болно. Энэ тохиолдолд Мэргэшлийн хороо сэтгэл зүйчийн дүгнэлтийг харгалзаж үнэлгээ өгнө.

3.1.1.2.д. ярилцлагын 30 оноог дараах үзүүлэлтээр үнэлнэ:

- хувь хүний хөгжил 10 оноо;
- хуульчийн болон шүүгчийн ёс зүйн төлөвшил 10 оноо;
- шүүгчээр ажиллах зан төлөв 10 оноо.

3.1.1.3. Намтар судлах 10 хүртэл оноо.

3.1.1.3.а.нэр дэвшигчийн намтрыг таньж мэдэх хүмүүстэй хийсэн ярилцлага, олон нийтийн мэдээлэл, баримт бичигт тулгуурлан судална. Мэргэшлийн хороо тохиолдлын аргаар нэр дэвшигчийн нэрийг гишүүдэд хуваарилж дараах шалгуураар үнэлнэ.

3.1.1.3.б.мэргэшлийн хорооны гишүүн хуваарилагдсан нэр дэвшигчтэй хамт сурч, ажиллаж байсан эсвэл сайн таньж мэдэх 3-аас доошгүй хүнтэй ярилцлага хийж, баталгаажуулна. Ярилцлагыг биечлэн эсвэл харилцаа холбооны бусад аргаар хийж болно. 4 оноо.

3.1.1.3.в.шүүгчийн сонгон шалгаруулалтад оролцож буй нэр дэвшигчдийг олон нийтэд мэдээлнэ. Мэдээлэл ирсэн тохиолдолд Мэргэшлийн хороо нягтлан шалгана. 2 оноо.

3.1.1.3.г.нэр дэвшигчийн дор дурдсан баримт бичгийг судалж, үнэлгээ өгнө. 4 оноо.

- анкет;
- гурван үеийн намтар;
- сахилгын болон бусад зөрчил, шийтгэл, гавьяа шагнал;
- боловсролын гэрчилгээ, диплом;
- мэргэжлийн болон ТББ-ын гишүүнчлэл;
- сонгуульт ажил;
- улс төрийн намын гишүүнчлэл;
- нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;
- Монголын хуульчдын холбооноос авсан нэр дэвшигчийн ёс зүйтэй холбогдох лавлагаа;
- ХАСХОМ.

3.1.2.Монгол хэлний бичгийн болон ярианы чадвар 20 хүртэл оноо.

3.1.2.1.бичгийн ур чадварыг 500-аас доошгүй үгтэй эссэ бичүүлж, дараах шалгуураар 10 хүртэл оноогоор үнэлнэ. Шалгалтын хугацаа 90 минут.

- Монгол хэлний дүрэм, найруулга зүй 5 оноо;
- мэргэжлийн нэр томъёо, хэллэгийг оновчтой, зөв ашигласан байдал 5 оноо.

3.1.2.2.ярианы чадварыг тохиолдлын журмаар сонгосон сэдвийг илтгүүлж, дараах шалгуураар 10 хүртэл оноогоор үнэлнэ. Шалгалтын хугацаа 10 хүртэл минут.

- өөрийн санаа бодлыг илэрхийлэх чадвар 3 оноо;
- илтгэх ур чадвар 3 оноо;
- илтгэх явцад өөрийгөө хянах, сэтгэл хөдлөлөө барих чадвар 4 оноо.

3.1.3.Хэрэглээний програм ашиглах чадвар 10 хүртэл оноо.

3.1.3.1.хэрэглээний програм ашиглаж баримт бичиг, мэдээлэл боловсруулах, хайлт хийх, түргэн бичих зэрэг даалгавраар шалгана. Түргэн бичилтийг 15 минутад бичсэн тэмдэгтийн тоогоор хувьчилж үнэлнэ. Шалгалтын хугацаа 90 минут.

- хэрэглээний програм ашиглах ур чадвар 6 оноо;
- түргэн бичилт 4 оноо.

3.2.Тусгай шалгалт.

3.2.1.Үндсэн хуулийн болон салбар эрх зүйн мэдлэг 30 хүртэл оноо.

3.2.1.1.Үндсэн хуулийн эрх зүйн мэдлэгийг сорил эсвэл тохиолдол шийдвэрлүүлэх аргаар шалгана. Сорилоор шалгах тохиолдолд нэг асуулт 0.25 оноотой байх бөгөөд 15 хүртэл оноогоор үнэлнэ. Тохиолдол шийдвэрлүүлэх бол энэ аргачлалын 2.2-т заасныг баримтална.

3.2.1.2.салбар эрх зүйн мэдлэгийг сорилоор шалгана. Сорилын нэг асуулт 0.25 оноотой байх бөгөөд 15 хүртэл оноогоор үнэлнэ.

3.2.2.Эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах 30 хүртэл оноо.

3.2.2.1.шүүхээс гарах эрх зүйн актын төрлөөс санамсаргүй сонголтоор сонгож, төсөл боловсруулна. Шалгалтын хугацаа 120 минут. Гүйцэтгэлийг дараах шалгуураар үнэлнэ:

- хууль зүйн техникийн шаардлага 10 оноо;
- хууль зүйн үндэслэл 10 оноо;
- нэр томъёоны сонголт, найруулга 10 оноо.

3.2.3.Хууль хэрэглэх мэдлэг, ур чадвар 40 хүртэл оноо.

3.2.3.1.нэр дэвшигч дагнасан шүүхийн салбар эрх зүйн тохиолдол шийдвэрлэнэ. Гүйцэтгэлийг үнэлэхдээ энэ аргачлалын 2.2-т заасныг баримтална. Шалгалтын хугацаа 240 минутаас доошгүй байна.

Дөрөв. Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн шалгалт

4.1.Тусгай шалгалт.

4.1.1.Хууль хэрэглэх мэдлэг, ур чадвар 40 хүртэл оноо.

4.1.1.1.нэр дэвшигч дагнасан шүүхийн салбар эрх зүйн тохиолдол шийдвэрлэнэ. Гүйцэтгэлийг үнэлэхдээ энэ аргачлалын 2.2-т заасныг баримтална. Шалгалтын хугацаа 240 минутаас доошгүй байна.

4.1.2.Шүүн таслах ажлын туршлага 30 хүртэл оноо.

4.1.2.1.нэр дэвшигчийн сүүлийн 3 жилийн хугацаанд хянан шийдвэрлэсэн хэргийн шийдвэрээс 5-ыг тохиолдлын аргаар сонгон дараах шалгуураар үнэлнэ.


- шийдвэрийн хуульд заасан шаардлага, техник 10 оноо;
- дээд шатны шүүхээс хэргийн шийдвэр хүчингүй болгосон, өөрчилсөн үндэслэл 10 оноо;

- шийдвэрийн үндэслэх, тогтоох хэсгийн бичилт 10 оноо

4.1.3.Магадлал бичих ур чадварын шалгалт 30 хүртэл оноо

4.1.3.1.анхан шатны шүүхийн аль нэг шийдвэрийг шүүхийн шийдвэрийн сангаас програмын аргаар нэр дэвшигчдийн өмнө сонгож, магадлалын төсөл бичүүлнэ. Шалгалтын хугацаа 120 минут. Гүйцэтгэлийг дараах шалгуураар үнэлнэ.

- хууль зүйн техникийн шаардлага 10 оноо;
- хууль зүйн үндэслэл 10 оноо;
- шийдвэрт хийсэн дүн шинжилгээ 10 оноо.



Тав. Хяналтын шатны шүүхийн шүүгчийн шалгалт

5.1.Суурь шалгалт.

5.1.1.Хяналтын шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд нэр дэвшигчийн суурь шалгалтыг энэ аргачлалын 3.1-д заасны дагуу гүйцэтгэнэ.

5.2.Тусгай шалгалт

5.2.1.Үндсэн хуулийн эрх зүйн мэдлэг 20 хүртэл оноо.

5.2.1.1.Үндсэн хуулийн эрх зүйн мэдлэгийг сорил эсвэл тохиолдол шийдвэрлүүлэх аргаар шалгана. Сорилоор шалгах тохиолдолд нэг асуултыг 0.25 оноогоор үнэлнэ. Тохиолдол шийдвэрлүүлэх бол гүйцэтгэлийг үнэлэхдээ энэ аргачлалын 2.2-т заасныг баримтална.

5.2.2.Хууль тайлбарлах ур чадвар 30 хүртэл оноо.

5.2.2.1.хууль тайлбарлах ур чадварыг тохиолдол шийдвэрлүүлэх аргаар шалгаж, 20 хүртэл оноогоор үнэлнэ. Гүйцэтгэлийг үнэлэхдээ энэ аргачлалын 2.2-т заасныг баримтална. Шалгалтын хугацаа 240 минутаас доошгүй байна.

5.2.2.2.хуулийн зүйл, заалтаас тохиолдлын журмаар ил тод сонгуулж, тайлбар бичүүлж, 10 хүртэл оноогоор үнэлнэ. Шалгалтын хугацаа 120 минут.

5.2.3.Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж, дүгнэлт бичих 30 хүртэл оноо.

5.2.3.1.анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг шүүхийн шийдвэрийн цахим сангаас нэр дэвшигчдийн өмнө програмын аргаар сонгож, дүн шинжилгээ хийнэ. Шалгалтын хугацаа 240 минутаас доошгүй байна. Гүйцэтгэлийг дараах шалгуураар үнэлнэ.

- цэгцтэй байдал ба бүтэц 5 оноо;
- талуудын тайлбарт хийсэн эрх зүйн дүн шинжилгээ 5 оноо;
- нотлох баримтын үнэлгээ 5 оноо;
- холбогдох хууль тогтоомжийн хэрэглээ 5 оноо;
- итгэл үнэмшил төрүүлэхүйц байдал 5 оноо;
- шүүхийн шийдвэр нэг мөр байх чанар 5 оноо.

5.2.4.Мэргэшсэн байдал 20 хүртэл оноо.

5.2.4.1. нэр дэвшигчийн мэргэшсэн байдлыг дараах шалгуураар үнэлнэ.

- эрдмийн бүтээлийн тоо, чанар 10 оноо;
- мэргэшиж ажилласан байдал 5 оноо;
- боловсролын зэрэг 5 оноо.



Зургаа. Ерөнхий шүүгчийн шалгалт

6.1. Тусгай шалгалт.

6.1.1. Манлайлал 20 хүртэл оноо.

6.1.1.1. нэр дэвшигчийн манлайллыг дараах аргаар үнэлнэ.

- удирдахуйн мэдлэг, түүнийг баримтлах эрмэлзлэлийг ярилцлагаар 5 оноо;
- хэргийн хөдөлгөөнийг удирдах чадварыг ярилцлагаар 5 оноо;
- манлайлах ур чадварыг шүүгч, ажилтнаас асуулгаар 10 оноо.

6.1.2. Хууль хэрэглэх мэдлэг, ур чадвар 40 хүртэл оноо.

6.1.2.1. нэр дэвшигч дагнасан шүүхийн салбар эрх зүйн тохиолдол шийдвэрлэнэ. Гүйцэтгэлийг үнэлэхдээ энэ аргачлалын 2.2-т заасныг баримтална. Шалгалтын хугацаа 240 минутаас доошгүй байна.

6.1.3. Шүүн таслах ажлын туршлага 40 хүртэл оноо.

6.1.3.1. нэр дэвшигчийн сүүлийн 3 жилийн хугацаанд хянан шийдвэрлэсэн хэргийн шийдвэрээс 5-ыг тохиолдлын аргаар сонгон дараах үзүүлэлтээр үнэлнэ.

- шийдвэрийн хуульд заасан шаардлага, техник 10 оноо;
- дээд шатны шүүхээс хэргийн шийдвэр хүчингүй болгосон, өөрчилсөн үндэслэл 10 оноо;
- шийдвэрийн үндэслэх, тогтоох хэсгийн бичилт 10 оноо;
- мэргэшсэн байдал, туршлага 10 оноо.

ooOOOoo